САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 2026/05

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2026.V	2025.V	2026.IV	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2026 оны 1-р улирал	их наяд ₮, оны үнээр	22.9	-	-	-	-	-	7.9% ▲
Инфляц	хувь	11.2	8.3	10.1	1.2% ▲	-	-	2.9% нэгж хувиар ▲
Ажилгүйдлийн түвшин	хувь	5.6% 2025 У4	5.3% 2024 У4	5.5% 2025 У3	-	0.1% нэгж хувиар ▲	-	0.3% нэгж хувиар ▲
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	-1,351.2	-260	-1,424.6	73 ▲	-	-	-1,091 ▼
Ам.долларын ханш	төгрөг	3,576.06	3,572.77	3,573.52	2.54 ▲	-	-	3.29 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	3,565.3	885	3,144.4	-	-	-	2,680.8 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	46.9	29.3	37.4	-	-	-	17.6 ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	1,089.2	852.1	889.9	-	-	-	237.1 ▲
Төв банкны бодлогын хүү	хувь	12%	12%	12%	-	-	-	-
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	7.73	5.19	7.32	5.54% ▲	-	-	48.89% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	5.29	5.24	5.24	0.05 нэгж хувиар ▲	-	-	0.05 нэгж хувиар ▲

ОНЦЛОХ СТАТИСТИК:	
ДНБ, 2026 оны эхний улиралд 7.9 хувиар өслөө.	ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр, 2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2026 оны эхний улиралд 6.7 их наяд төгрөг болж, өмнөх оны эхний улиралтай харьцуулахад 491.2 (7.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 309.7 (33.6%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарынх 139.8 (4.1%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:		
Шийдвэрүүд	**Огноо**	**Зорилго, үр дүн**
Бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа	2026-06-24	Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2026 оны 6 дугаар сарын 23, 24-ний өдрүүдийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, дотоод, гадаад орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа..

САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 2026/05

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

График	Нөлөөлөл
	Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2026 оны 5 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар, өмнөх сараас 1.2 хувиар тус тус өссөн байна. 2026 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд барааны бүлгийн үнэ 12.3 хувь, үйлчилгээний бүлгийн үнэ 7.8 хувь, хүнсний бүлгийн үнэ 23.4 хувь, хүнсний бус бүлгийн үнэ 6.6 хувиар тус тус өссөн байна.
	Америк долларын ханш 2026 оны 5 дугаар сард 3,576.06 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.29 төгрөгөөр, өмнөх сараас 2.54 төгрөгөөр тус тус чангарсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 5.54%-иар, өнгөрсөн жилийн мөн үеэс 48.89%-иар тус тус өсөж 7.73 тэрбум ам.долларт болов.
	Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2026 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 13.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1 (18.7%) их наяд төгрөгөөр, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 11.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 960.0 (9.0%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2026 оны эхний 5 сард 13.0 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарчээ. Төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1.1 их наяд төгрөг буюу 5.2 дахин өссөн байна.
	Монгол Улс 2026 оны эхний 5 сард нийт 145 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.4 тэрбум ам.доллар болсон байна. Үүнээс экспорт 8.5 тэрбум ам.доллар, импорт 4.9 тэрбум ам.доллар болж, тэнцэл 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.4 (34.6%) тэрбум ам.доллар, экспорт 3.1 (56.9%) тэрбум ам.доллар, импорт 367.5 (8.1%) сая ам.доллар, тэнцэл 2.7 (4.1 дахин) тэрбум ам.долларoop тус тус өссөн байна.
Дэлхийн эдийн засагт	АНУ, Ираны талууд эхний ээлжийн уулзалтынхаа үр дүнг зарлав https://ikon.mn/n/3ofz

Эх сурвалж:

1. *Статистикийн бюллетень, 5-р сар 2026 он, Үндэсний статистикийн хороо*
2. *www.1212.mn, www.mongolbank.mn*